



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 29 өдөр

Дугаар А/104

Булган сум

### “1 жуулчинд – 1 хонь” хөтөлбөрийн аяллыг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны II/04 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.2.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX Хуралдааны XIX/08 тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх хүрээнд Хангал, Гурванбулаг, Рашаант сум, Хялганат тосгонд “1 жуулчинд – 1 хонь” төсөл хөтөлбөрт оролцох Nasdaily студийн Япон, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хонг Конг мужийн инфлүүнсэрүүдийн (олон мянган дагагчтай) аяллыг 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдрөөс 2024 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр хүртэл хугацаанд зохион байгуулсугай.

2. Дээрх ажлын санхүүжилтийг 7,271,900 (долоон сая хоёр зуун далан нэгэн мянга есөн зуу) төгрөгийг Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний, аялал жуулчлалын эвент арга хэмжээ зохион байгуулах төсөл арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

